



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 13 өдөр

Дугаар А/21

Мандалговь

Аймгийн аварга малчин өрх, саальчин,
фермер, тариаланч шалгаруулах журам
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3."а" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн ээлжит хуралдааны тэмдэглэл, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 2 дугаар хуралдааны тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Аймгийн аварга малчин өрх шалгаруулах журам"-ыг 1 дүгээр, "Аймгийн аварга саальчин шалгаруулах журам"-ыг 2 дугаар, "Аймгийн аварга фермер шалгаруулах журам"-ыг 3 дугаар "Аймгийн аварга тариаланч хамт олон", "Аймгийн аварга тариаланч шалгаруулах журам"-ыг 4 дүгээр хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Хүнс хөдөө аж ахуйн газрын дарга (Б.Мөнхжаргал), Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Гурав. Энэ захирамж гарсантай холбогдуулан харьяа нутаг дэвсгэртээ малынхаа тоог бэлчээрийн даацад тохируулсан, чанарыг нь сайжруулж нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлсэн, нэгжээс хураан авах ургац, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, хүн амын хүнсний хангамжийг хангахад оруулсан хувь нэмэр зэрэг шалгуур үзүүлэлтүүдийн дагуу тодорхойлон ирүүлж байхыг сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Дөрөв. Шинэчлэн баталсан журмыг 2021 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдөж, "Журам батлах тухай" Аймгийн Засаг даргын 2017 оны А/10, 2018 оны А/581 дүгээр захирамжийг мөн өдрөөс тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

481213044